

Э-Сонин

28 дахь дугаар

Мэдээний Тойм



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААНЫ МЭДЭЭЛЭЛ

ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААСНЫ ӨГӨӨЖ БАНКНЫ ХАДГАЛАМЖААС ӨНДӨР БАЙНА



ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН НЭЭЛТТЭЙ ӨДӨРЛӨГ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛЛАГДЛАА

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО БОЛОН МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ШИЙДВЭРҮҮД



2015 ОНД НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ КОМПАНИУД

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛД ШИНЭ ТОГТОЛЦОО НЭВТЭРНЭ



ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН 3-Р САРД ЗАРЛАГДСАН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОВ ГАРЛАА

Д.АНГАР: МХБ 8.5 САЯ АМ.ДОЛЛАРЫН ӨРТЭЙ



ТӨГСӨЛТИЙН БАЯ

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЛЭГ ОЛГОХ ЭЭЛЖИТ СУРГАЛТ ӨНДӨРЛӨЛӨӨ

ҮЙЛ ЯВДЛЫН ХУРААНГУЙ

- ЗГЖҮЦ-ны 2 дугаар сарын арилжааны мэдээлэл.
- Засгийн газрын үнэт цаасны хүүгийн хэмжээг арилжааны банкны ижил хугацаат хадгаламжийн хүүтэй харьцуулахад харьцангуй өндөр байна.
- “Үнэт цаасны зах зээлийн нээлттэй өдөрлөг” арга хэмжээг Монголын хөрөнгийн бирж дээр зохион байгуулж, нийт 6300 хүнд нэг цэгийн үйлчилгээг үзүүллээ
- Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржийн шийдвэрүүд.
- Ногдол ашиг хуваарилах шийдвэрлэсэн хувьцаат компаниудын мэдээлэл.
- “Market Makers” буюу “Итгэмжлэгдсэн дилер”-ийн тогтолцоог зэх зээлд шинээр нэвтрүүлэхээр боллоо.
- Д.Ангар: МХБ 8.5 сая ам.долларын өртэй байна.

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ

- 2-р сарын арилжааны мэдээ

СУРГАЛТ


“Үнэт цаасны зах зээлийн анхан шатны суурь мэдлэг олгох” сургалт-ыг 2015 оны 3 дугаар сарын 23-ны өдөр явуулахаар төлөвлөж байна. Дэлгэрэнгүй мэдээллийг 11313747 /116 дугаараас авна уу.



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААНЫ МЭДЭЭЛЭЛ

Засгийн газрын жижиглэнгийн үнэт цаасны /Нэгжийн үнэ 100,000 төгрөг/ захиалгыг долоо хоног бүрийн Лхагва гарагаас дараа долоо хоногийн Мягмар гараг хүртэл авч, арилжааг зохион байгуулж байна. Хоёрдугаар сард тус үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг 4 удаа зохион байгуулж нийт 25.7 тэрбум төгрөгийн гүйлгээг хийсэн байна.

Өдөр	ЗГҮЦ-ны нэр	Хугацаа /7 хоног/	Зарагдсан тоо хэмжээ /ш/	Хүүгийн хэмжээ	Үнийн дүн /төгрөг/
2015.02.03	ЗГЭБ-Б-52-287	52	1,652	16.125%	165,200,000.00
2015.02.10	ЗГЭБ-Б-12-288	12	21,874	14.896%	2,114,909,564.00
2015.02.17	ЗГЭБ-Б-28-289	28	8,987	15.745%	828,637,348.00
2015.02.24	ЗГЭБ-Б-12-290	12	233,886	14.846%	22,607,186,874.00
Нийт зарагдсан ЗГҮЦ			266,399		25,715,933,786.00






ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААСНЫ ӨГӨӨЖ БАНКНЫ ХАДГАЛАМЖААС ӨНДӨР БАЙНА

Монголын хөрөнгийн биржээр Засгийн газрын үнэт цаасыг арилжиж эхэлснээс хойш тус үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг 17 удаа зохион байгуулж нийт 97.9 тэрбум төгрөгийн /Нэрлэсэн үнээр/ үнийн дүн бүхий үнэт цаасыг арилжаад байна.

Засгийн газрын үнэт цаасны хүүгийн хэмжээг арилжааны банкны ижил хугацаат /12 долоо хоног буюу 3 сар/ болон /28 долоо хоног буюу 6 сар/ хадгаламжийн хүүтэй тус тус харьцуулахад харьцангуй өндөр байна.

Үнэт цаасыг эзэмшиж байх хугацаанд мөнгө шаардлагатай болсон тохиолдолд уг үнэт цаасны хугацаа дуусахыг хүлээх шаардлагагүйгээр зах зээл дээр эргүүлэн худалдаж, эзэмшсэн хугацааныхаа хүүг авах боломжтой ба хүүгийн орлого нь татвараас бүрэн чөлөөлөгддөгөөрөө онцлогтой юм.



ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААСНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛ

№	Анхдагч зах зээлийн арилжаа явагдсан өдөр	ЗГҮЦ-ны нэр	MIT Арилжааны системийн симбол	Хугацаа /Тхоног/	Хүүгийн хэмжээ	Нэрлэсэн үнэ	Хямдруулсан үнэ	Хүү төлөгдөх хэлбэр	Дуусах хугацаа
1	2014.11.04	ЗГЭБ-Б-12-274	ZGEB-BL-27/01/15-A0001-0	12	15.795	100,000	96,493	хямдруулсан	2015.01.27
2	2014.11.11	ЗГЭБ-Б-52-275	ZGEB-BD-10/11/15-A0002-16.25	52	16.25	100,000	-	Сар бүр	2015.11.10
3	2014.11.18	ЗГЭБ-Б-12-276	ZGEB-BL-10/02/15-A0003-0	12	15.99	100,000	96,451	хямдруулсан	2015.02.10
4	2014.11.25	ЗГЭБ-Б-28-277	ZGEB-BL-09/06/15-A0004-0	28	16.3	100,000	91,952	хямдруулсан	2015.06.09
5	2014.12.02	ЗГЭБ-Б-12-278	ZGEB-BL-24/02/15-A0005-0	12	15.96	100,000	96,457	хямдруулсан	2015.02.24
6	2014.12.09	ЗГЭБ-Б-52-279	ZGEB-BD-08/12/15-A0006-16.625	52	16.625	100,000	-	Сар бүр	2015.12.08
7	2014.12.16	ЗГЭБ-Б-12-280	ZGEB-BL-10/03/15-A0007-0	12	15.731	100,000	96,506	хямдруулсан	2015.03.10
8	2014.12.23	ЗГЭБ-Б-28-281	ZGEB-BL-07/07/15-A0008-0	28	16.436	100,000	91,890	хямдруулсан	2015.07.07
9	2014.12.30	ЗГЭБ-Б-12-282	ZGEB-BL-24/03/15-A0009-0	12	15.653	100,000	96,523	хямдруулсан	2015.03.24
10	2015.01.13	ЗГЭБ-Б-12-284	ZGEB-BL-07/04/15-A0010-0	12	14.690	100,000	96,730	хямдруулсан	2015.04.07
11	2015.01.20	ЗГЭБ-Б-28-285	ZGEB-BL-04/08/15-A0011-0	28	15.292	100,000	92,411	хямдруулсан	2015.08.04

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН НЭЭЛТТЭЙ ӨДӨРЛӨГ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

2015 оны 2-р сарын 6, 7 –ны өдрүүдэд “ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН НЭЭЛТТЭЙ ӨДӨРЛӨГ” арга хэмжээг Монголын хөрөнгийн бирж дээр зохион байгуулж, нийт 6300 хүнд нэг цэгийн үйлчилгээг үзүүллээ.

Нээлттэй өдөрлөгийн хүрээнд: иргэдийн дунд хүлээлт үүсгээд байгаа Эрдэнэс таван толгой ХК-ийн 1072 хувьцааг иргэн бүрт эзэмшүүлэх асуудлаар мэдээлэл өгч, ягаан цэнхэр тасалбартай холбоотой дансны мэдээллийг шүүх, ногдол ашгийн мэдээллийг өгөх, арилжааны данс нээх, иргэдийн өргөдөл гомдлыг хүлээн авч шийдвэрлэх зэрэг үйлчилгээг үзүүллээ.

Түүнчлэн аж ахуйн нэгжүүдэд зориулан хөрөнгийн зах зээлээс мөнгө босгох боломж, хөрөнгө оруулалтын зөвлөгөөг өгч үнэт цаасны зах зээлтэй холбоотой иргэдийн сонирхсон бүх асуулт, санал хүсэлтэд үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн байгууллагууд хариулт өгч ажиллаа.



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО, МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ШИЙДВЭРҮҮД

ЗАРИМ ҮЦК-ИЙН АРИЛЖААНД ОРОЛЦОХ ЭРХИЙГ СЭРГЭЭЛЭЭ

2015 оны 1-р улирлын гишүүнчлэлийн үйлчилгээний төлбөрийг бүрэн төлөөгүй нэр бүхий 10 үнэт цаасны компанийн арилжаанд оролцох эрхийг 2015 оны 2 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн түр хязгаарласан билээ. Дараах компаниуд гэрээнд заасан үүргээ биелүүлж гишүүнчлэлийн үйлчилгээний төлбөрөө төлсөн тул арилжаанд оролцох эрхийг нь сэргээлээ.

- | | |
|-------------------------------|------------------------------|
| 1 “Ард Капитал Групп ҮЦК” ХХК | 2 “Монсек ҮЦК” ХХК |
| 3 “Эм Ай Си Си ҮЦК” ХХК | 4 “Гүүдсек ҮЦК” ХХК |
| 5 “Масдак ҮЦК” ХХК | 6 “Монгол Секюритис ҮЦК” ХХК |

БИНСЭ ХК –ИЙН НЭМЭЛТ ХУВЬЦААГ ТЭРГҮҮН ЭЭЛЖИНД ХУДАЛДАН АВАХ ЭРХ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАР

Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 01 сарын 28-ны өдрийн 70 тоот тогтоолоор Бинсэ ХК-ийн хувьцааны тоог 1,000,000 ширхгээр нэмэгдүүлэх шийдвэр гаргасан байна.

“Компанийн тухай хууль”-ийн 38-р зүйлд заасны дагуу хувьцаа эзэмшигчдэд тэргүүн ээлжинд худалдан худалдан авах эрхийг хэрэгжүүлэх үнийг компанийн ТУЗ-өөс 1,000 төгрөг байхаар тогтоосон байна.

Иймд “Бинсэ”ХК-ийн хувьцаа эзэмшигч та бүхэн уг эрхээ хэрэгжүүлэхдээ өөрийн харилцдаг брокер дилерийн компаниар дамжуулан 2015 оны 03 сарын 18-ны өдрийн дотор хүсэлтээ компанид гаргаж нэмэлт хувьцааг тэргүүн ээлжинд авах боломтой болсон байна.

"ЖИНСТ УВС" ХК БОЛОН "ӨНДӨРХААН" ХК –УУДЫН ХУВЬЦААНЫ ХЯНАЛТЫН БАГЦЫГ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ САНАЛЫГ ИРҮҮЛСЭН БАЙНА

“Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”-ийн 22.1.1, 22.4 заалтын дагуу хяналтын багцыг худалдан авах санал гаргагч нь СЗХ болон нийтэд зэрэг мэдэгдэж, хувийг биржид ирүүлсний дараа багцын арилжааг зохион байгуулах боломжтой юм.

Иймд дээрх хуулийн холбогдох заалтын дагуу Даваацэрэн овогтой Төгсбаяр, Буян-Өлзий овогтой Цэнгэлмаа, Даваа овогтой Сожил нь “Жинст увс” ХК-ийн нийт гаргасан хувьцааны хяналтын багц болох 84.6% буюу 45,028 ширхэг хувьцааг нэг бүрийг нь 100 төгрөгөөс доошгүй үнээр худалдан авах санал мөн Ойдовсүрэн овогтой Наранхүү нь Хэнтий аймгийн “Өндөрхаан” ХК-ийн нэр бүхий хүмүүсийн эзэмшиж байсан 91,443 ширхэг хувьцаа буюу нийт хувьцааны 81.7%-ийн хяналтын багц хувьцааг тус тус худалдан авах санал гаргасныг нийтэд мэдээлэлж байна.

2015 ОНД НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ КОМПАНИУД



“ГЕРМЕС” ХК

Тус компанийн ТУЗ-ын хурал 2015.02.12-ны өдөр хуралдаж, 02 тоот тогтоолоор 2014 оны жилийн эцсийн нийт цэвэр ашгийн 95% буюу 320,000,000.00 төгрөгийг хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хэлбэрээр тараахаар шийдвэрлэж, нэгж хувьцаанд 4 төгрөг 07 мөнгөөр хуваарилахаар болсон байна.

“ТАВАНТОЛГОЙ” ХК

2014.04.30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 02 тоот тогтоолоор 2013 оны жилийн эцсийн цэвэр ашгаас нэгж хувьцаанд 766 төгрөг хуваарилахаар шийдвэрлэж байсан билээ. Харин 2015.01.23 өдөр хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдаж 2013 оны жилийн эцсийн ногдол ашгийг 5 хувиар нэмэгдүүлж нэгж хувьцаанд 59 төгрөг нэмж хуваарилахаар болсон байна.

“ТАХЬ КО” ХК

Тус компанийн ТУЗ-ын хурал 2015.02.11-ний өдөр хуралдаж, 03 тоот тогтоолоор 2014 оны жилийн эцсийн нийт цэвэр ашгаас нэгж хувьцаанд 82 төгрөг хуваарилахаар шийдвэрлэв.

“МОНИНЖБАР” ХК

Тус компанийн ТУЗ-ын хурал 2015.02.13-ний өдөр хуралдаж, 04/2015 тоот тогтоолоор 2014 оны жилийн эцсийн нийт цэвэр ашгаас нэгж хувьцаанд 5 төгрөг хуваарилахаар шийдвэрлэв.

“ГОВЬ” ХК

Тус компанийн ТУЗ-ын хурал 2015.02.12-ний өдөр хуралдаж, 02 тоот тогтоолоор 2014 оны жилийн эцсийн нийт цэвэр ашгаас нэгж хувьцаанд 140 төгрөг хуваарилахаар шийдвэрлэв.

МХБ-ИЙН БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ ШИНЭЧЛЭГДЭН БАТЛАГДЛАА

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны 1 дүгээр сарын 21-ний өдрийн хурлаар компанийн үйл ажиллагааны дунд хугацааны стратеги төлөвлөгөө, 2015 оны бизнес төлөвлөгөө болон байгууллагын бүтцийг шинэчлэн баталсан.

Батлагдсан бүтцийн хүрээнд Гүйцэтгэх захирлын 2015 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 36 тоот тушаалаар Арилжаа, хяналтын албаны захирлаар М.Энхтуяа, Стратеги, зах зээлийн хөгжлийн албаны захирлаар Б.Чингүүнжав, Маркетинг, олон нийттэй харилцах албаны захирлаар Ж.Мягмарсүрэн, Мэдээллийн технологийн албаны захирлаар З.Батгэрэл, Санхүү төлөвлөлтийн албаны захирлаар Г.Цэвээндорж, Захиргааны албаны захирлаар Ж.Нарантуяа нарыг тус тус томиллоо.

Шинэ бүтцээр Тэргүүн дэд захирал, дэд захирал, газрын захирал зэрэг орон тоонууд хасагдаж нийт 45 хүний батлагдсан орон тоотойгоор 2015 онд ажиллана.

**ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН 3-Р САРД ЗАРЛАГДСАН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОВ ГАРЛАА**

	Компаний Нэр	Хуралдах Он сар өдөр	Цаг	Хурлаар хэлэлцэх асуудлууд
1	“Мон-Ит Булигар” ХК	2015.03.05	10:00	2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах, компанийн дүрэмд өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэх
2	“Сонсголог Бармат” ХК	2015.03.09	10:00	2014 оны үйл ажиллагааны ба санхүүгийн тайлан, компанийн дүрэмд өөрчлөлт оруулах, ТУЗ-ийн тайлан, ТУЗ-ийг сонгох болон бусад асуудлыг хэлэлцэх
3	“Мон Наб” ХК	2015.03.12	14:00	2014 оны үйл ажиллагааны ба санхүүгийн тайланд ТУЗ-н өгсөн дүгнэлт, ТУЗ-н ажлын тайлан, компанийн үйл ажиллагааны цаашдын зорилтыг батлах асуудлыг хэлэлцэх
4	“Техник Импорт” ХК	2015.03.16	09:00	2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, түүнд хийсэн аудитын дүгнэлтийн талаар ТУЗ-аас гаргасан дүгнэлт, компанийн 2015 оны ажлын төлөвлөгөө, компанийн Аудитын хорооны тайлан, компанийн дотоод бүтэц, зохион байгуулалт болон бусад асуудлыг хэлэлцэх
5	“Газар Сүлжмэл” ХК	2015.03.19	16:00	2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, ногдол ашиг хуваарилах асуудлыг хэлэлцэх
	“Блюскай Секьюритиз” ХК	2015.03.25	18:00	2014 оны санхүүгийн үйл ажиллагааны тайлан болон 2015 оны бизнес төлөвлөгөөг батлах, компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах, нэмэлт хувьцаа гаргах төслийг хэлэлцэн батлах зэрэг асуудлыг хэлэлцэх
6	“Би Ди Сек” ХК	2015.03.26	10:00	2014 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлангийн аудитаар баталгаажсан дүгнэлтийг тайлагнах, компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн ТУЗ-ийн дүгнэлт бүхий тайлан, ТУЗ-ийн ногдол ашиг тараах эсэх талаар гаргасан шийдвэр, ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох, ТУЗ-ийн 2015 оны цалин урамшууллын төсөв, компанийн нэрэнд өөрчлөлт оруулах, нэмэлт хувьцааны арилжааны тайлан, шинээр татан төвлөрүүлсэн хөрөнгөтэй холбоотойгоор бизнес төлөвлөгөө, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тодотголыг танилцуулах, үнэт цаасны танилцуулгын өөрчлөлтийг хувьцаа эзэмшигчдэд танилцуулах, компанийн зарласан болон гаргасан хувьцааны тоог тогтоох, компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцэхээр
7	“Дижитал Каталист” ХК	2015.03.27	12:00	2014 оны үйл ажиллагааны санхүүгийн тайлан, үйл ажиллагааг өргөжүүлэх худалдан авалт болон холбогдох бүх гэрээ хэлцэл, хөрөнгийн үнэлгээг батлах, өрийг хувьцаагаар солих төсөл батлах, компанийн дүрэмд өөрчлөлт оруулах, болон бусад асуудлыг хэлэлцэх
8	“Хөнгөн Бетон” ХК	2015.03.27	17:00	2014 оны үйл ажиллагааны санхүүгийн тайланг хэлэлцэх, ТУЗ-ийн гишүүдийг сонгох, гишүүдийн урамшууллын хэмжээг тогтоох, Компанийн 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах, компанийн дүрэмд өөрчлөлт оруулах, болон бусад асуудлыг хэлэлцэх
9	“Хархорин” ХК	2015.03.28	14:00	2014 оны санхүүгийн үйл ажиллагааны тайлан болон 2015 оны бизнес төлөвлөгөөг батлах, ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг хэлэлцэх, их хэмжээний хэлцэл хийх тухай ТУЗ-ийн шийдвэрийг батлах, ТУЗ-ийн гишүүдийг сонгох зэрэг асуудлуудыг хэлэлцэх
10	“Говь Файненшл” ХК	2015.03.30	12:00	2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэх, компанийн цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны болон үнэт цаасны төсөл төлөвлөгөөг батлах, компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, нэмэлт хувьцаа гаргах, үйл ажиллагаагаа өргөжүүлэхээр компани худалдан авах хэлцэл, холбогдох тайлан, үнэлгээ дүгнэлт, гэрээ хэлцэлүүдийг батлах, өрийг хувьцаагаар солих, их хэмжээний хэлцэл түүнчлэн шаардах эрх хэрэгжүүлэх, тэргүүн ээлжинд хувьцаа худалдан авах асуудлуудыг хэлэлцэх

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛД ШИНЭ ТОГТОЛЦОО НЭВТЭРНЭ

Үнэт цаасны арилжааг идэвхжүүлж, хөрвөх чадварыг сайжруулахад мэргэжлийн дилерийн үйл ажиллагаа чухал үүрэгтэй байдаг. Хэдийгээр Монголын хөрөнгийн биржийн гишүүн үнэт цаасны компаниуд нь брокер болон дилерийн давхар эрхтэй байдаг боловч ихэнх үйл ажиллагаа нь зөвхөн брокерийн буюу харилцагчийн даалгавраар үнэт цаас худалдах, худалдан авах захиалгыг биелүүлэх чиглэлээр хязгаарлагдаж байна.



Үүнээс шалтгаалж хөрөнгө оруулагч хүссэн үнэт цаасаа худалдан авч чадахгүй эсвэл өөрийн эзэмшлийн үнэт цаасаа хүссэн цагтаа зарж чадахгүйд хүрдэг бөгөөд энэ нь нийт зах зээлийн хөрвөх чадварт сөргөөр нөлөөлж ирсэн. Тиймээс Монголын хөрөнгийн биржээс 2015 оны 2 дугаар сарын 16-наас эхлэн олон улсын хөрөнгийн зах зээлийн стандарт дэд бүтэц болох “Market Makers” буюу “Итгэмжлэгдсэн дилер”-ийн тогтолцоог нэвтрүүлэхээр бэлтгэл ажлыг хангаад байгаа ба өнөөдөр Монголын

хөрөнгийн биржийн гишүүн үнэт цаасны компаниудаас “БиДиСек”, “Стандарт инвестмент”, “Тэнгэр капитал”, “Капитал маркет корпораци” зэрэг 4 компани “Итгэмжлэгдсэн дилер”-ийн батламж авч, гэрээнд гарын үсэг зурлаа.



Үүний хүрээнд Засгийн газрын үнэт цаасанд “Итгэмжлэгдсэн дилер”-ийн тогтолцоог нэвтрүүлж байгаа юм. Ингэснээр “Итгэмжлэгдсэн дилер” үнэт цаасны компаниуд Монголын хөрөнгийн биржийн арилжааны өдөр бүр Засгийн

газрын үнэт цаас худалдах, худалдан авах үнийн саналыг давхар гаргах бөгөөд үнэт цаасны хүртээмж нэмэгдэж, хөрөнгө оруулагчид Засгийн газрын үнэт цаасыг өдөр бүр худалдан авах эсвэл төлбөр төлөх хугацаанаас өмнө эргүүлэн худалдах боломж нээгдэж, анхдагч болон хоёрдогч зах зээлийн хөрвөх чадвар нь нэмэгдэх боломж бүрдэх юм.



Д.АНГАР: МХБ 8.5 САЯ АМ.ДОЛЛАРЫН ӨРТЭЙ



-Үнэт цаас, төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төвийн дансанд 11 тэрбум төгрөг байршиж байгаа тухай таярьж байсан. Энэ нь ямар учиртай мөнгө юм бэ?

- Хөрөнгийн захын үйл ажиллагаа ил тод, нээлттэй байх учиртай. Үүнийг хангаж байж л зах зээл оршин тогтдог. Гэтэл Үнэт цаас, төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв үүнээс гажиж, хувьцаа эзэмшигчдэд очих ёстой 11 тэрбум төгрөгийг өөр дээрээ удаан хугацаагаар төвлөрүүлж байсан нь ил болсон. Ногдол ашиг болон хувьцааны мөнгийг эзэнд нь хүргэх талаар дорвитой ажил хийлгүй өдийг хүргэсэн байна. Тиймээс иргэд ногдол ашиг болон хувьцаагаа сураглаж, мөнгөө олж авах хэрэгтэй.

-Иргэдийн мөнгө эргэлтэд орохгүй, хүү бодогдохгүй зүгээр л сул хэвтэж байжээ?

-Ер нь бол тийм. Хөрөнгийн зах зээлийн гол тоглогч нь хүний мөнгийг удаан хугацаагаар нуудаг байж болохгүй. Ийм байвал зах зээл хөгжихгүй. Хувьцаа эзэмшигчдэд 11 тэрбум төгрөгийг цаг тухайд нь тараасан бол тэд идэвхтэй хөрөнгө оруулагч болон хувирах байсан. Хуримтлагдсан ногдол ашгаараа дахиж хувьцаа авах, мөнгөө өсгөж болох юм байна гэсэн итгэл үнэмшил бэхжих байлаа. Дээрх асуудал нь хөрөнгийн зах зээлийн хөгжлийг чөдөрлөсөн. Иргэд ч ялгаагүй үүнээс болж багагүй алдагдал хүлээсэн.

-Танайх шаардлага тавьж болдоггүй юм уу?

-Эрх зүйн хувьд тусдаа байгууллага учраас манайхаас ямар ч шаардлага хүргүүлэх боломжгүй л дээ.

-Хөрөнгийн биржээр дамжуулан хувьцаа гаргах гэсэн компаниудын санал танайд хэр ирж байна вэ?

-Эдийн засгийн нөхцөл байдал хүнд байгаа учраас ойрын хоёр жилийн хугацаанд томоохон хэмжээний IPO хийгдэхгүй нь шинжтэй. Хөрөнгө татъя гэвэл юуны өмнө дотоодын хөрөнгө оруулагчдаа тэлэх хэрэгтэй байна. Хөрөнгийн биржийг дэлгүүр гэж үзвэл

тэнд олон төрлийн чанартай бараа, бүтээгдэхүүн байх ёстой. Гэвч энэ шаардлагыг манайд бүртгэлтэй

хувьцаат компаниудын дийлэнх нь хангаж чадахгүй байгаа юм. Тэр тусмаа компанийн сайн засаглалыг мөрддөг компани гэж алга. Биржээр дамжуулан хөрөнгө босгох, нэмж хувьцаа гаргах санал одоогоор ирээгүй байна.

-Иргэдийн зах зээлд оролцох хандлага сүүлийн үед хэр сэргэсэн бэ?

-Иргэдийн хөрөнгийн зах зээлийн ойлголт, санхүүгийн боловсрол тааруухан хэвээр байна. Ягаан, цэнхэр тасалбарын үлдэгдэл, “Эрдэнэс Тавантолгой”-н 1072 ширхэг хувьцаагаа л иргэд голдуу асууж лавладаг. Түүнээс зах зээлийн өөр шинэ бүтээгдэхүүнд хөрөнгө оруулалт хийх, энэ талаар сонирхох нь ховор. Үүнээс гадна Хөрөнгийн биржийн нэр хүнд тааруухан байна. Тиймээс бирж өөрөө институцийн хувьд хөгжих ёстой. Хүний итгэлийг төрүүлдэг байх учиртай. Ингэснээр иргэдийн хандлага нааштай эргэнэ. Хөрөнгө оруулагчийн хүрээ байхгүй, хувьцаа компаниуд нь төлөвшөөгүй зах зээлийг гаднын томоохон хөрөнгө оруулалтын сангууд тоохгүй. Тиймээс дотоодын хөрөнгө оруулагчдыг нэн тэргүүнд бий болгох шаардлагатай байгаа нь Засгийн газрын үнэт цаасаар илэрч, сая тод харагдлаа.

-Иргэд Засгийн газрын бондын талаар төдийлөн сайн мэдэхгүй. Үүнийг ухуулан таниулсан ажил ч бага хийгддэг. Дотоодын хөрөнгө оруулагчид нь иргэд бий эдэв?

-Тиймээ. Иргэд бол хөрөнгийн зах зээлийн хөдөлгөгч хүч нь. Бонд хамгийн энгийн бүтээгдэхүүн. Гэтэл хамгийн энгийн бүтээгдэхүүнийг худалдаж авч сураагүй, эзэмшиж мэдэхгүй байна. Засгийн газрын үнэт цаас банкны

хадгаламжаас бүх талаар давуу талтай. Эрсдэлгүй, өндөр өгөөжтэй, олон талаар ашиглаж болно. Хувь хүн худалдаж авах боломжтой. Түүнийгээ тендерийн баталгаа болгох, бусдад бэлэглэх, үр хүүхдэдээ ч өвлүүлж болно. Хэрэв мөнгөний шаардлага гарвал түүнийгээ хоёр дахь зах зээл дээр зараад мөнгөө буцаагаад авч болдог. Хэрэв олон нийтийн санхүүгийн боловсрол сайн байсан бол ийм бүтээгдэхүүнийг булаацалдаад авах байсан. Харамсалтай нь идэвх төсөөлж байснаас харьцангуй доогуур байлаа.

-Одоогоор хэчнээн төгрөгийн Засгийн газрын бонд арилжаалаад байна вэ?

-Засгийн газрын 74 тэрбум төгрөгийн бонд арилжаалсан байна. Гурван сарын хугацаанд дээрх хэмжээний бондыг зарна гэдэг амжилт. Өмнө нь бондыг дөрвөн банк л авдаг байсан. Одоо 150 орчин иргэн, аж ахуйн нэгж худалдан аваад байна.

-Хөрөнгийн бирж 2015 онд ямар бодлого, чиглэлтэй ажиллахаар төлөвлөж байна вэ?

-Биржийн зүгээс энэ онд цоо шинэ бүтээгдэхүүн санаачлах, зах зээлд оруулахаас илүүтэй дотоодын хөрөнгө оруулагч нараа чанаржуулах, мэдлэгийг нь дээшлүүлэх, тэдний итгэлийг Хөрөнгийн бирж олоход гол анхаарлаа хандуулна. Манайд зах зээлийн дэд бүтэц сайтар бүрдээгүй. Хөрөнгийн зах зээл гэдэг өөрийн гэсэн тогтсон дүрэмтэй байдаг. Тиймээс олон нийтийн хандлагыг өөрчлөх, зах зээлийн давуу талыг сурталчлахад бодлогоо чиглүүлнэ.

-Хөрөнгийн биржийн хувьцааны тодорхой хэсгийг олон нийтэд нээлттэй арилжаалах санал бүхий хуулийн төсөл УИХ-д өргөн баригдсан. Бирж хөгжлийнхөө шатанд хувьчлагдах нь зөв үү?

-Манайх шиг төрийн өмчит хөрөнгийн бирж одоо бараг байхгүй. Хөрөнгийн бирж ил тод, компанийн засаглалтай, бизнесийн зарчмаар үйл ажиллагаа явуулдаг байх ёстой. Гаднын орнуудад хөрөнгийн бирж нээлттэй компани байдлаар үйл ажиллагаа явуулдаг. Ихэнх хувийг нь иргэд, аж ахуйн нэгж эзэмшиж байна. Тодруулбал,

манайхтай хамтран ажиллаж буй Лондоны хөрөнгийн бирж нээлттэй компани. Хувьцааных нь бараг 40 хүртэлх хувийг арабууд эзэмшиж байх жишээтэй. Хэдий нээлттэй компани болсон ч хяналтын багцаа хадгалж явдаг. Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлбэ, эдийн засгийн тулгуур болгоё гэвэл хөрөнгийн биржийг хэзээ нэг өдөр хувьчлах нь зөв. Үнэтэй, үнэгүй байна гэдэг дараагийн асуудал. Энэхүү ажлыг хийж чадах хүнд нь хувьчлах ёстой.

-Лондоны хөрөнгийн биржтэй байгуулсан хамтын ажиллагааны гэрээг өнгөрсөн жил үргэлжлүүлэн сунгасан. Өмнөх үйлчилгээний төлбөр нь бүрэн хийгдсэн үү?

-Монголын хөрөнгийн бирж Лондоны хөрөнгийн биржтэй нийт 14 сая ам.долларын үнийн дүн бүхий Стратегийн хамтын ажиллагааны гэрээ байгуулж, хамтран ажилласан. Үүний тодорхой хэсгийг улсын төсвөөс төлсөн. Үлдсэнийг нь арилжааны банк болон Хөгжлийн банкнаас зээл авч барагдуулсан.

-Танайх одоо нийт хэчнээн төгрөгийн өртэй байгаа вэ?

-Манай нийт өрийн хэмжээ 8.5 сая ам.долларт хүрсэн. Төгрөгөөр тооцвол 15 орчим тэрбум болж байна. Мөн татварын өртэй бий. Сүүлийн хоёр сарын хугацаанд Татварын газраас манай дансыг хаана гэсэн шаардлага хүртэл ирүүлэх болсон. Тухайлбал, татварт нэг тэрбум төгрөг төлөхөөр байна. Хөрөнгийн бирж өөрөө 8.5 сая ам.долларыг төлөх боломжгүй. Улсын төсвөөс л төлнө.

-Танайх жилд хэчнээн төгрөгийн зардал гаргадаг вэ?

-Жилдээ нэг тэрбум төгрөгийн зардал гаргадаг. Үүний 600 сая нь цалин, 200 нь элэгдэл, хий зардал болдог. Үлдсэн 200 сая төгрөг нь гэрэл цахилгаан, үйлчилгээний зардалд явж байна. Сүүлийн гурван жил турш хөрөнгийн бирж алдагдалтай ажилласан бол өнгөрсөн сард 50 сая төгрөгийн цэвэр ашигтай гарлаа. Нийтдээ 130 сая төгрөгийн орлого олсон. Үүний 80 сая нь зарлага болж, үлдсэн 50 саяараа Засгийн газрын үнэт цаас худалдаж авсан. Ашигтай ажиллана гэдэг зах зээлд эерэг мэдээлэл болж байдаг.

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЛЭГ ОЛГОХ
ЭЭЛЖИТ СУРГАЛТ ӨНДӨРЛӨЛӨӨ



ТӨГСӨЛТИЙН БАЯР



“Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК-ийн “Үнэт цаасны зах зээлийн мэдлэг олгох” анхан шатны ээлжит сургалт 2015 оны 2 дугаар сарын 23-наас 27-ны хооронд явагдаж дууслаа.

Сургалтыг онол-практикийг хослуулан Брокер, дилерийн компанийн үйл ажиллагаатай танилцуулах, арилжаанд оролцуулах хэлбэрээр явуулсан нь суралцагчдын сонирхолд ихэд нийцсэн сургалт боллоо.

Энэ удаагийн сургалтад амжилттай суралцсан 14 суралцагч сертификат гардан авлаа.

Сургалтад цаашид хамрагдах сонирхолтой иргэд, оюутан залуусын тоо өдрөөс өдөрт нэмэгдэж байгаа нь нийгмийн эрэлт хэрэгцээ их байгаагийн илрэл юм. Иймд бид дараагийн сургалтыг 2015 оны 3 дугаар сарын сүүлээр 23-ны өдрөөс явуулахаар төлөвлөж байна.

Үнэт цаасны зах зээлийн боловсролоо дээшлүүлэх үйлсэд Тань амжилт хүсье



ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААНЫ МЭДЭЭ

2015 оны 2 дугаар сар

Арилжааны товч мэдээ

Арилжигдсан ширхэг	7,163,540
Нийт үнийн дүн	26,993,733,810
Хэлцлийн тоо	889
Арилжигдсан үнэт цаасны тоо	66
Зах зээлийн үнэлгээ	1,365,432,388,305

ТОП-20 индекс

Хаалт	13,907.69
Өмнөх сарын хаалт	14,290.63
Өөрчлөлт /нэгж/	-382.94
Өөрчлөлт /%/	-2.68
52 долоо хоног дээд	17,160.49
доод	14,389.27



Идэвхтэй арилжигдсан үнэт цаас:

Тоо ширхэгээр:					Үнийн дүнгээр:				
№	Симбол	Үнэт цаасны нэр	Арилжсан ширхэг	Үнийн дүн	№	Симбол	Үнэт цаасны нэр	Арилжсан ширхэг	Үнийн дүн
1	ETR	Э- ТРАНС ЛОЖ ИСТИК	5,012,586	501,199,080	1	ETR	Э- ТРАНС ЛОЖ ИСТИК	5,012,586	501,199,080
2	АНН	ХОРИНХОЁРДУГААР БИРЖ	1,318,569	270,306,645	2	АНН	ХОРИНХОЁРДУГААР БИРЖ	1,318,569	270,306,645
3	ОНН	ӨНДӨРХААН	91,443	9,144,300	3	АПУ	АПУ	17,730	64,179,870
4	RMC	РЕМИКОН	74,700	6,710,175	4	МІЕ	МАТЕРИАЛИМПЕВ	1,529	43,430,500
5	HRM	ГЕРМЕС ЦЕНТР	69,819	9,898,342	5	ВНВ	БАЯЛАГ НАЛАЙХ	60,917	40,918,970

Хамгийн их өсөлттэй үнэт цаас:

№	Симбол	Үнэт цаасны нэр	Өмнөх сарын хаалт	Хаалтын ханш	Ханшийн өөрчлөлт	
					төгрөг	%
1	SHV	ШИВЭЭ ОВОО	3,900.00	6,200.00	2,300.00	58.97
2	SUL	ГАЗАР СҮЛЖ МЭЛ	46,200.00	58,650.00	12,450.00	26.95
3	HNS	ХӨВСГӨЛ ХҮНС	591.15	680.00	88.85	15.03
4	SOI	ЕВРОАЗИА КАПИТАЛ	21.16	24.33	3.17	14.98
5	HGN	ХӨХ ГАН	97.00	110.07	13.07	13.47

Хамгийн их бууралттай үнэт цаас:

№	Симбол	Үнэт цаасны нэр	Өмнөх сарын хаалт	Хаалтын ханш	Ханшийн өөрчлөлт	
					төгрөг	%
1	IBA	ИХ БАРИЛГА	11,000.00	8,000.00	-3,000	-27.27
2	HSX	ХИШИГ УУЛ	945.00	800.00	-145	-15.34
3	BSKY	БЛЮ СКАЙ СЕКЬЮРИТИ	2,975.00	2,529.00	-446	-14.99
4	MNS	МОННООС	4,700.00	4,000.00	-700	-14.89
5	MKT	НАКО ТҮЛШ	309.00	264.00	-45	-14.56

Засгийн газрын үнэт цаас: /анхдагч зах зээл/

№	Үнэт цаасны нэр	Арилжсан ширхэг	Үнийн дүн	Хүүгийн хэмжээ % /жил/	Нэрлэсэн үнэ	Хямдруулсан үнэ
1	ЗГЭБ-Б-52-287	1,652	165,200,000	16.125	100,000	100,000
2	ЗГЭБ-Б-12-288	21,874	2,114,909,564	14.896	100,000	96,686
3	ЗГЭБ-Б-28-289	8,987	828,637,348	15.745	100,000	92,204
4	ЗГЭБ-Б-12-290	233,886	22,607,186,874	15.019	100,000	96,659

Засгийн газрын үнэт цаас: /хоёрдогч зах зээл/

№	Үнэт цаасны нэр	Арилжсан ширхэг	Үнийн дүн	Хүүгийн хэмжээ % /жил/	Нэрлэсэн үнэ	Хямдруулсан үнэ
1	ZGEB-BD-10/11/15-A0002-16.25	50	5,000,000	16.25	100,000	-
2	ZGEB-BL-05/05/15-A0014-0	1,240	119,895,600	14.90	100,000	96,686